

**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ**

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024.05.03 № 03/3447

танай _____-ны № _____-т

Гомдол гарсан тухай

Танай байгууллагаас зарласан ТБ/20240203233 дугаартай “Мэдээллийн аюулгүй байдлын олон улсын стандарт хэрэгжүүлэлтийн үйлчилгээ үзүүлэх” тендер шалгаруулалтад оролцсон “Систем центр” ХХК-аас гаргасан гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.8 дахь хэсэг болон Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-д заасны дагуу захиалагчаас ирүүлсэн холбогдох баримт материалд үндэслэн хянан үзлээ.

“Систем центр” ХХК-ийн гомдолд захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Инфо сек плас” ХХК-ийн тендерт ирүүлсэн хүний нөөц ТШББ-ийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 18.1-д заасан үндсэн ажилтан байх, ISO/IEC 27001 lead auditor эсхүл ISO/IEC 27001 lead implementer сертификаттай байх, мөн ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн туршлагын шаардлагад ирүүлсэн гэрээг үнэн эсэхэд эргэлзэж байх тул захиалагчийн шийдвэрийг хянан үзэхийг хүссэн байна.

Гомдол дурдсаны дагуу захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Инфо сек плас” ХХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзлээ.

1.Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 18.1-д “Үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн шаардлага: багийн ахлагч - 1, багийн гишүүн 2 байх бөгөөд үндсэн ажилтан байх. Үндсэн ажилтны нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг сүүлийн 3 сараар Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан шалгана. (Регистерийн дугаарыг тодорхойлж ирүүлнэ)” гэж заасан байна.

“Инфо сек плас” ХХК-ийн тендерт ирүүлсэн хүний нөөцийн мэдээлэлд багийн ахлагч Л.Хонгорзул, багийн гишүүн Ч.Сэлэнгэ, У.Ганбаяр, Т.Нямжаргал, Т.Тэлмүүн нарыг тус тус санал болгосон байна.

Сангийн сайдын 2023 оны А/248 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын 2.5-д заасны дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д “Инфо сек плас” ХХК-ийн ирүүлсэн хүний нөөцийн мэдээллийг шалгахад багийн ахлагч Л.Хонгорзул, багийн гишүүн Т.Тэлмүүн нар даатгуулагчийн төрлийн 40001 кодоор буюу үндсэн ажлаас гадуур зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ажилтнаар тус компанид

нийгмийн даатгал төлдөг байгаа нь шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байна.

2.Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 18.1-д "Багийн аль нэг гишүүн нь ISO/IEC 27001 lead auditor эсхүл ISO/IEC 27001 lead implementer сертификаттай байна. /Сертификатыг онлайнаас баталгаажуулж ирүүлэх бөгөөд тухайн баталгаажуулалтын дагуу шалгах зааврын хамт ирүүлнэ." гэж заасан байна.

"Инфо сек плас" ХХК-ийн тендерт ирүүлсэн хүний нөөцийн мэдээлд заасан (<https://pecb.com/en/userCertification/certificateVerification>) цахим хуудаснаас багийн ахлагч Л.Хонгорзулын мэдээллийг зааврын дагуу шалгахад 2027 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр хүртэл хүчинтэй ISLA1033419-2024-01 дугаартай ISO/IEC 27001 Lead Auditor сертификаттай, багийн гишүүн Ч.Сэлэнгийн мэдээллийг <https://www.udemy.com/certificate/UC-9c7e4407-22f2-4d91-96d0-7f2d59ef4bda/> цахим хуудаснаас шалгахад UC-9c7e4407-22f2-4d91-96d0-7f2d59ef4bda дугаартай ISO/IEC 27022 Lead Implementer сертификаттай байгаа нь ТШББ-ийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 18.1-д заасан "Багийн аль нэг гишүүн нь ISO/IEC 27001 lead auditor эсхүл ISO/IEC 27001 lead implementer сертификаттай байх" шаардлагад нийцэх эсэхийг нягталж үзэх нь зүйтэй байна.

3.Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 18.1-д "2022, 2023 онуудын аль нэг жилд батлагдсан төсөвт өртгийн 100 хувиас багагүй үнийн дүнтэй ISO27001:2013 эсхүл ISO27001:2022 стандартын дагуу үйлчилгээ үзүүлж хүлээлгэн өгсөн байна. Тус зөвлөх үйлчилгээ авсан байгууллага нь ISO27001:2013 эсхүл ISO27001:2022 сертификат нь баталгаажсан байх ба сертификатын хуулбар ирүүлнэ. Гэрээний хуулбар ирүүлнэ. Гэрээний үүргээ биелүүлсэн тухай захиалагчийн тодорхойлолт эсхүл гэрээ дүгнэсэн акт /бараа хүлээлцсэн акт/-ыг ирүүлнэ." гэж, ТШЗ 2.1-д "Нийт төсөвт өртөг: 65,000,000.0 /жаран таван сая/ төгрөг" гэж тус тус заасан байна.

"Инфо сек плас" ХХК тендерт "Хатан суудал инвест" ББСБ-тай 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан 03/Г-022/011 дугаартай "ISO/IEC 27001 стандарт нэвтрүүлэлтийн зөвлөх" үйлчилгээний гэрээ /гэрээний үнэ: 80,000,000.0 төгрөг/, "Хатан суудал инвест" ББСБ-ын ISO27001:2013 сертификат, захиалагчийн тодорхойлолт тус тус ирүүлсэн байна.

Тус компанийн ирүүлсэн "Хатан суудал инвест" ББСБ-тай байгуулсан 03/Г-022/011 дугаартай гэрээний 1 ба 2-6 дугаар хуудасны үсгийн фронт зөрүүтэй, түүнчлэн гэрээний 1 дүгээр хуудас хар тамгатай, 2-6 дугаар хуудас өнгөт тамгатай байх тул тус асуудлыг нягталж үзэх нь зүйтэй байна.

Тодруулгаар хуулийн 56 дугаар зүйлийн 56.5 дахь хэсэгт заасан нөхцөл илэрвэл оролцогчийн талаарх мэдээллийг холбогдох нотлох баримтын хамт хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.10 дахь заалтад заасны дагуу худалдан авах ажиллагааны улсын байцаагчид хянуулахаар тус яаманд ирүүлнэ үү.

Иймд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.1 дэх заалтыг үндэслэн захиалагчийн 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 17/2111 тоот шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэж байна.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 55.10.3 дахь заалтад үндэслэн тендер шалгаруулалтын тендерийн үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийхийг мэдэгдье

Хувийг: "Систем центр" ХХК-д.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Ж.ГАНБАТ